

“Та нар миний гар

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх,
Ерөнхийлөгч Диетер Ф. Угдорф

Есүс Христийн шавь нар бид бусдыг буруутгах бус харин дэмжиж, эдгээхийн тулд дуудагдсан юм.

Дэлхийн II Дайны үед нэгэн хотод Есүс Христийн том хөшөө бөмбөгдөлтөнд өртөж, сүрхий эвдэрч гэмтсэн тухай нэгэн түүх байдаг. Тэр хотын оршин суугчид хөшөөг нуранги дотроос олоод ихэд гашууджээ. Учир нь тэр хөшөө тэдний хувьд итгэлийн мөн Бурхан амьдралд нь оршдогийг сануулдаг хайртай бэлэг тэмдэг байжээ.

Мэргэжлийн засварчид хөшөөний ихэнх хэсгийг сэргээн засварласан боловч гар нь засч болохооргүй эвдэрч хэмхэрсэн байв. Зарим хүмүүс уран барималч хөлслөн шинэ гар хийлгэх санал тавьсан боловч нэг хэсэг нь дайны хор хөнөөлийг хэзээ ч мартаггүйн тулд гаргүй чигээр нь үлдээх нь зөв гэж үзэж байв. Эцэст нь хөшөөг гаргүй чигээр нь үлдээсэн аж. Гэсэн ч хотынхон Есүс Христийн хөшөөний суурин дээр “Та нар бол миний гар” гэж бичжээ.

Бид Христийн гар мөн

Энэ түүхээс бид их зүйлийг сурч болно. Би Аврагчийн тухай бодохдоо Түүнийг урагш гараа сунгасан байхаар төсөөлдөг. Тэр биднийг тайтгаруулан эдгээхээр, адислан хайрлахаар гараа урагш сунгадаг. Тэр хэзээ ч хэн нэгнийг дорд үзэж байгаагүй бөгөөд даруу төлөв хүмүүсийг хайрлан тэдний дунд амьдарч, тэдэнд үйлчлэн, итгэл найдвар ба авралыг хайрласан юм.

Мөнх бус амьдралынхаа хугацаанд Тэр тийн үйлдэж байсан юм. Хэрэв Тэр өнөөдөр бидний дунд амьдарч байсан бол мөн л их үйлсийг хийх байсан. Бид Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд, Түүний шавь нар нь болохын хувьд түүн лугаа үйлдэн амьдрах ёстой.

Христийн амилалтын баярын энэ сайхан өглөө бидний бодол санаа, зүрх сэтгэл Израилын Итгэл найдвар, Дэлхийн Гэрэл болсон Түүн уруу чиглээд байна.

Бид Түүний төгс жишээг даган амьдарснаар бидний гар Түүний гар, бидний нүд Түүний мэлмий, бидний зүрх сэтгэл Түүний зүрх сэтгэл болж чадна.

Бидний гар гэвэрч чадна

Манай сүмийн гишүүд бусдад хэрхэн үйлчилж байгааг хараад надад гүн сэтгэгдэл төрдөг. Бид та нарын хийсэн золиослол болон энэрлийн үйлсийг сонсоод маш их баярлан талархдаг билээ. Та нар дэлхийд гялалзах гэрэл бөгөөд дэлхий даяарх сайн сайхан, энэрэнгүй үйлсээр тань хүмүүс та нарыг таних болно.

Харамсалтай нь сүмийн зарим гишүүд маань өөрсдийгөө сүмд тохирохгүй гэсэн бодлоосоо урам нь хугарч, улмаар Сүмийнхээ цуглаануудад оролцохоо больсон талаар бид хааяа сонсдог.

Намайг хүүхэд байхад дэлхийн хоёрдугаар дайны дараа Герман улс эвдэрч сүйрсэн балгасаар дүүрсэн байлаа. Олон хүмүүс өлсгөлөн болон өвчнөөр үхэж байв. Тэр үед Солт Лейк Хотын Сүмээс ирдэг байсан хүмүүнлэгийн хүнс болон хувцасны тусламжийг би тодхон санаж байна. Одоо хүртэл тэдгээр хувцас хунарын үнэр, лаазалсан тоор жимсний амт санаанаас гардаггүй юм.

Тухайн үед тусламж авсан хүмүүсээс сүмд орсон хүмүүс байсан нь лавтай. Үүнээс нь болоод зарим сүмийн гишүүд эдгээр шинэ хөрвөгчдөд дургүй байв. Тэр бүү хэл тэд шинэ хөрвөгчдийг *Büchsen Mormonen* буюу “Лаазалсан хоолны Мормончууд” гэж гомдоомоор нэр хоч өгдөг байлаа. Тэд шинэ хөрвөгчдийг хүлээн авахгүй байсан гол шалтгаан нь шинэ гишүүд түр зуурын гачигдлаасаа гарангуутаа л сүмээс холдон, дахин эргэж ирэхгүй гэж боддог байснаас тэр биз.

Хэдийгээр тэдний зарим нь идэвхгүй болж сүмээс гарсан ч, олон хөрвөгчид үлдэж, сүмдээ ирсээр байсан бөгөөд сайн мэдээний үр шимийг болон тусархаг ах эгч дүү нарынхаа тэврэлтийг мэдэрсэн юм. Тэд “жинхэнэ гэрээ” олсон бөгөөд тэднээс хойш гурав, дөрвөн үе өнгөрсөн ч олон гэр бүлүүд тэдгээр хөрвөгчдийн үр удам болохоо олж мэдсээр байгаа юм.

Бурханы бүх хүүхдүүдийг тэр дундаа өөрөөр хувцаслах, харагдах, ярих, эсвэл зүгээр л өөрөөр юмаа хийдэг хэнийг ч болов бид хүлээж авна гэдэгт би найдаж байна. Бусдыг ялгаварлан үзэх нь ноцтой нүгэл гэдгийг санагтун. Харин эргэн тойронд маань байгаа хүмүүсийг дэмжиж, нөхөрлөлийн гараа тэдэнд сунгацгаая. Тэдгээр Сүмийн гишүүн ах эгч нарт эцсийн эцэст “жинхэнэ гэрээ” олсон мэт мэдрэмж төрүүлж чадах хүмүүнлэг зан, нинжин сэтгэл, энэрэл хайрыг үзүүлцгээе.

Бид бусдыг шүүхээр уруу татагдсан үед “дэлхийг хайрладаг, бүр Тэрээр бүх хүмүүнийг өөртөө ойртуулж болохын тулд Тэр амиа өгснийг” санацгаая. . .

“Харин тэр хэлдэг: Дэлхийн хязгаарууд та нар бүгд надад ирэгтүн, . . . [учир нь] “. бүх хүмүүн нэг нь нөгөөгийнхөө адил эрх бүхий бөгөөд нэг нь ч үл хориглогдсон болой.”¹

Судруудыг уншиж байхад ихэвчлэн эд хөрөнгө, эрх мэдэл эсвэл өөрсдийгөө зөвт хэмээн итгээд хэт их хүндэтгэл хүлээсэн хүмүүс Аврагчийн хамгийн хатуу зэмлэлийг хүлээн авдаг нь харагддаг.

Нэг удаа Аврагч сүмд залбирахаар очсон хоёр хүний тухай сургаалт зүйрлэлийг заасан. Олны хүндэтгэлийг хүлээсэн фарисай болох тэдний нэг нь “Бурхан, Тандаа би талархъя. Юу гэвэл би бусад хүмүүс шиг зальхай, шударга бус, завхай бишээ. Тэр ч байтугай энэ татвар хураагч шиг биш билээ. Би долоо хоногт хоёр удаа мацаг барьж, олсон бүгдийнхээ аравны нэгийг өргөдөг” гэв.

Харин олон түмний үзэн ядалтыг хүлээсэн нөгөө “татвар хураагч нь зайдуу зогсоод, тэнгэр өөд харж ч зүрхлэлгүй, харин цээжээ дэлсэн байж, “Бурхан минь, нүгэлт намайг өршөөгөөч”² гэв. Тэгээд Есүс “Би та нарт хэлье, фарисай нь биш, харин нөгөө хүн зөвтгөгдөн гэртээ харив” гэж айлджээ.

Үнэндээ бол “бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй.”³ Бид бүгдэд нигүүлсэл хэрэгтэй. Бурханы өмнө шүүгдэхээр зогсох тэр эцсийн өдөр олон

дутагдал маань уучлагдана гэдэгт бид найддаггүй гэж үү? Бид Аврагчийн тэврэлтийг мэдрэхийг мөрөөддөггүй гэж үү?

Бид өөрсөддөө хүсэх зүйлээ бусдад өгөх ёстой нь хамгийн зөв бөгөөд тохирох хариулт гэж бодож байна.

Бид хувийн амьдралдаа эсвэл дэлхийд нүглийг хүлээн зөвшөөрч, хилэнцийг тоохгүй байхыг би зөвлөж байгаа юм биш шүү. Гэхдээ заримдаа бид хүсэл тэмүүлэлдээ автан нүгэл, нүгэлтэн хоёрыг андуурч хэтэрхий түргэн шийдвэр гарган энэрэлгүйгээр бусдыг буруутгадаг. “Бодгалийн үнэ цэнэ Бурханы мэлмийд агуу гэдгийг”⁴ бид орчин үеийн судраас олж мэддэг. Ертөнцийг хэмжиж чадахгүйтэй адил бид бусдын амь хэр үнэ цэнэтэй болохыг хэмжиж үл чадна. Бидний харсан хүн болгон Бурханы хувьд маш чухал хүмүүс юм. Үүнийг ойлгосны дараа бид бусадтай хэрхэн харьцах ёстойгоо мэдэж эхэлдэг.

Олон жил зовлон бэрхшээлийг туулж амьдарсан нэгэн эмэгтэй нулимс асгаруулан: “Би өөрийгөө үрчийж үнгэгдэн урагдаж аймаар болсон 20 долларын дэвсгэртэй зүйрлэж байна. Гэхдээ 20 долларын дэвсгэртийн үнэ цэнэ хэвээр байдгийн адил би ч үнэ цэнэтэй юм. Би хэдийгээр амьдралд нухлагдан хөгширч сайхан харагдахгүй байгаа ч би ч мөн бүтэн 20 долларын үнэ цэнэ хэзээд хэвээрээ байдгийн адил юм шүү” гэж билээ.

Бидний гар тайтгарлыг өгч чадна

Хүн бүр өөр өөрийн бэрхшээлтэй тулгарч байдаг болохоор бусдад зүрх сэтгэлээ нээж, тусламжийн гараа сунгацгаая. Бидний Эзэн, Есүс Христийн шавь нар болох бид тэднийг буруутгах бус харин дэмжиж тэтгэх ёстой. Гашуудах тэдний хамт гашуудаж, тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруул хэмээн бидэнд зарлигласан.⁵

Зовж яваа хүнийг хараад ингэж байхдаа таарсан хүн гэж бодох нь Христэд итгэдэг бидний хувьд зохисгүй хэрэг. Христийн амилалтын баярын энэ өдөр бол бид бүгдийн төлөө, тэр бүү хэл бүр зовлонг хүртэх үйлтэй хүмүүсийн төлөө өвчин, шаналлыг Аврагч Өөр дээрээ авсан гэдгийг санан дурсах сайхан өдөр мөн.⁶

“Анд найзууд ямар ч үед бие биеэ хайрладаг. Ах дүү нар хэцүү цагт дэм болохын төлөө төрдөг”⁷ гэсэн сургаалт үгсийг санацгаая. Бие биеэ цаг ямагт хайрлаж явцгаая. Нэн ялангуяа гай зовлон тохиолдсон ах, эгч, дүү нартаа тусалцгаая.

Бидний гар үйлчилж чадна

Хамтдаа газар хагалан амьдардаг Абрам ба Зимрай гэгч ах дүү хоёрын тухай эртний нэгэн иудей домог байдаг. Тэр хоёр ажлаа ч, ургацаа ч эн тэнцүү хувааж авч байхаар тохирч гэнэ. Ургацаа хурааж дууссаны дараа нэгэн шөнө Зимрай унтаж чадсангүй. Учир нь эхнэр, долоон хүүхэдтэй Абрам ургацын зөвхөн талыг авч байхад ганц бие түүний хувьд энэ нь дэндүү шударга бус мэт санагдаж гэнэ.

Ингээд Зимрай хувцсаа өмсөн, талбай уруугаа очиж, хураасан ургацынхаа гуравны нэгийг ахынхаа ургацтай нийлүүлэн тавиад зөв юм хийсэндээ сэтгэл хангалуун орондоо оржээ.

Тэр үеэр Абрамын нойр бас хулжсан байв. Ургац хураалцах ч хүүхэдгүй ганцаараа л зүтгэх ядарсан дүү Зимрайгаа өрөвджээ. Зимрай хамаг хүчээ шавхаж, ганцаараа

хөдөлмөрлөчихөөд ургацынхаа зөвхөн талыг авах нь шударга бус юм шиг түүнд санагджээ. Бурхан лав үүнийг таалахгүй гэж бодоод тэр чимээгүйхэн талбайдаа очин, ургацынхаа гуравны нэгийг хайртай дүүгийнхаа хураасан ургацтай нийлүүлэн тавьжээ.

Өглөө болж ах дүү хоёр талбайдаа гарахад тэдний хураасан ургац огт өөрчлөгдөөгүй ижил хэмжээтэй байхыг хараад ихэд гайхацгааж гэнэ. Тэр оройдоо урьд шөнийн хийсэн зүйлээ дахин хийхээр ах дүү хоёр гэрээсээ сэмээрхэн гаран явжээ. Гэвч энэ удаад тэр хоёр тааралдан, бие биенээ хараад зүрх сэтгэл нь хайр, талархлаар дүүрэн үг ч хэлэх сөхөөгүй уйлан, тэврэлдэн зогссон гэдэг.⁸

Энэ бол бусдыг өөрийн адил хайрла, тэдний аз жаргалыг эрэлхийл, өөрсөддөө хэрхэн хандаасай гэж хүсдэгчлэн өөрсдөө ч мөн тийнхүү тэдэнд ханд хэмээх энэрэл нигүүлслийн сүнс юм.

Жинхэнэ хайр үйлдлийг шаардана

Жинхэнэ хайр үйлдлийг шаарддаг. Бид хайрын тухай өдөржин ярьж, түүнийг тунхаглан тэмдэглэл болон шүлэг бичиж, хайрын тухай магтан дуулж, түүнийг урамшуулан дэмжих номлолыг номлосон ч чадна. Гэвч бид хайрыг үйлдлээрээ харуулж чадахгүй бол бидний үгс “нүргэлэх харанга, хангинах цан” мэт хоосон, юу ч биш юм.

Христ хайрын тухай ярихаасаа илүү Өөрийн амьдралын өдөр бүрийн үйлдлээрээ харуулж байлаа. Тэр олон түмнээс холдон зайлаагүй бөгөөд хүмүүсийн дунд ядарсан нэгэнд тусалж, алдагдсан нэгнийг авардаг байв. Тэр зөвхөн хичээлээр хайрлах тухай заачихаад, дараа нь бодит үйлдлээ зөвхөн бусдаар хэрэгжүүлж байхаар биднийг томилоогүй юм. Тэр зөвхөн заагаад зогсоогүй, Өөрийн биеэр хэрхэн “сул доройчуудад тусалж, доош унжсан гарнуудыг өргөж, мөн сул дорой өвдөгнүүдийг хүчирхэг болгохыг”¹² бидэнд бас харуулсан билээ.

Бусдад хэрхэн төгс үйлчлэхийг Христ л хамгийн сайн мэддэг. Аврагч тусламжийн гараа сунгахад Түүний гарт хүрсэн хүмүүс урам зориг орж, илүү хүчирхэгжин, улмаар зөвт хүмүүс болон хувирдаг.

Хэрэв бид Түүний гар юм бол Түүний хийх байсан зүйлсийг л хийх ёстой биш гэж үү?

Бид Түүний адилаар хайрлаж чадна

“Бүх хууль болоод эш үзүүлэгчид тулгуурладаг”¹³ хоёр агуу зарлигийг Аврагч хайр хэмээн нэрлэснээр бидний амьдрал, гэр орон, тойрог, нийгэм хамт олон, улс орны хэмжээнд энэ тэргүүнд баримтлах төгс зүйлийг илчилсэн юм. Бид амьдрал, хууль дүрмийн нарийн чимхлүүр ажил, хийх ёстой үй олон ажил үйлст санаа тавин, цаг заваа өнгөрүүлдэг. Гэвч агуу зарлигуудыг үл ойшоовоос бид салхинд туугдсан хургүй үүл, үр жимсгүй хатсан мод лугаа адил байх болно.¹⁴

Бурхан Эцэг болон хөршөө хайрлах энэхүү хайр байхгүй бол бид хоосон хөндий, зөвхөн хэлбэрийн төдийд Түүний Сүм байх болно. Хайр байхгүй бол бидний

сургаал ямар ашигтай юм бэ? Хайр байхгүй бол номлол, ариун сүм, халамжийн ажил ямар ашигтай юм бэ?.

Хайр бол бидний сүнснийг бүтээхэд Тэнгэрлэг Эцэгт сүнслэгээр нөлөөлсөн тэр зүйл мөн. Хайр бол Аврагчийг хүн төрөлхтний нүглийн төлөөсийг хийхийн тулд Гетсеманий Цэцэрлэг уруу хөтөлсөн тэр зүйл юм. Хайр бол авралын төлөвлөгөөний агуу хөдөлгөгч хүч, аз жаргалын эх сурвалж, эдгээн шинэчлэх рашаан булаг, итгэл найдварын үнэт эх ундарга юм.

Бид Христийн хайраар бусдад тусламжийн гараа сунгавал бидэнд гайхамшиг тохионо. Бидний сүнс илааршиж, илүү цэвэр, бат бөх итгэлтэй болно. Бид улам их аз жаргалтай, амар амгалан, Ариун Сүнсний шивнээг илүү сайн сонсох чадвартай болно.

Хайрт ах, эгч, дүү, найз нар минь, Хүүгээ бидэнд бэлэглэсэн Тэнгэрлэг Эцэгтээ би чанга дуугаар талархлаа илэрхийлж байна. Би бүх зүрх сэтгэлээсээ Есүс Христийн амьдрал ба жишээнд, Түүний нүгэлгүй, аминч бус золиослолд талархаж байна. Тэр үхээгүй, харин амилсан гэдэгт би баярлаж байна! Тэр амьд бөгөөд хүмүүнд Өөрийн эрх мэдэл болон сайн мэдээг сэргээхээр энэ дэлхийд эргэн ирсэн. Бид чухам ямар хүмүүс байх ёстойн төгс үлгэр жишээг Тэр бидэнд өгсөн билээ.

Христийн амилалтын баярын энэ ням гарагт, мөн өдөр бүр Аврагч маань биднийг хэрхэн тэврэн авч, тайтгаруулан эдгээсний нэгэн адил бүгдээрээ Түүний гар болж, Түүний хайраар дүүрэн тэврэлтийг бусдад мэдрүүлж байхаа амлацгаая. Есүс Христийн нэрээр, амен.

Эшлэл

1. 2 Нифай 26:24–28; онцлон тэмдэглэлт нэмсэн болно.
2. Лук 18:9-14-ийг үз.
3. Ром 3:23.
4. Сургаал ба Гэрээ 18:10.
5. Мозая 18:9.
6. Алма 7:11–13; Сургаал ба Гэрээ 19:16-г үз.
7. Сургаалт Үгс 17:17.
8. Кларенс Кук, “Abram and Zimri,” in *Poems, by Clarence Cook* (1902), 6–9-ийг үз.
9. Матай 22:39-ийг үз.
10. Матай 7:12-ыг үз.

11. 1 Коринт 13:1.

12. Сургаал ба Гэрээ 81:5.

13. Матай 22:40.

14. Иуда 1:12-ыг үз.